

ЦААСАН ХАЙРЦГААР СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН ХИЙЖ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ

Цаасан хайрцгаар сургалтын хэрэглэгдэхүүн хийж орчин бүрдүүлэх нь хүүхэд багштай хамтарч орчингоо бүрдүүлж хийж байгаа нь хүүхдэд маш сонирхолтой, түүнээсээ мэдлэг олж авахад туслах сайн сургалтын хэрэглэгдэхүүн болж чадлаа.

Сургалтын хэрэглэгдэхүүний нэр: Галууны байр, хашаа

Ашиглах материал хэрэглэгдэхүүн :

- Цаасан хайрцаг / сайн чанарын том 3ш /
- Цаас зүсэгч
- Халаадаг цавуу
- Скоч

Хийх аргачлал:

- Цаасан хайрцгаа задлана.
- Галууны байрныхаа оройг ижил 2 ширхэгийг гурвалжилж зүснэ.
- Байрныхаа 4 талыг ижил хэмжээтэй зүснэ
- 4 цонхыг гаргаж зүснэ
- 4 талыг барьж халаадаг буугаар нааж тогтооно.
- Байрныхаа оройг нийлүүлж нааж тогтооно.
- Цонхыг хийхдээ ижил 10см хэмжээтэй 4 ширхэг нарийхан зүсэж наана.
- Хашааг хийхдээ цаасан хайрцгаа задлана.
- Хашаа нь 50см-н өндөртэй байна.
- Цаасан хайрцгаа ижил хэмжээтэй нарийхан шугамдана.
- Шугамдсан хэсгээ зүсэж авна.
- 2 хашаагаа зөрүүлж наана.
- Хашаагаа хооронд нь холбоно.
- Хүүхдүүдтэйгээ хамтарч хашаагаа навчаар чимнэ.
- Хашаан дотор Галууны нугалмай хүүхдүүдээр хийлгэж, орчин бүрдүүлнэ.
- Хийсэн сургалтын хэрэглэгдэхүүнээ ярилцана.

Ач холбогдол, үр дүн :

- Хүүхэд өөрсдийн хамтарч хийсэн бүтээлээр бахархана.
- Эрүүл ахуйн шаардлага хангасан, хүүхдэд аваар осолгүй, өнгө үзэмж сайтай сургалтын хэрэглэгдэхүүн.
- Цаасан хайрцаг олдох боломжтой, эдийн засгийн хэмнэлтэй.
- Өөр сэдвийн хүрээнд орчин бүрдүүлж ашиглах боломжтой.
- Бат бөх , хүүхэд орчиндоо галууны тухай ярилцах, галуугаа хооллох , хашааг цэвэрлэх гэх мэтээр тоглох боломжтой.
- Сургалтын хэрэглэгдэхүүн хийхэд ямар ч хүндрэл гараагүй, хүүхдүүдтэйгээ ярилцаж хамтарч хялбар аргаар хийхэд илүү сонирхолтой байсан.

Дорнод аймаг Хэрлэн сумын 12-р цэцэрлэгийн

Багш Д. Урансүх

Туслах багш Б. Отгонжаргал

